



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Тохижилт үйлчилгээний ангийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2025/119/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2025 он

Дарга, тэргүүлэх аудиторовын албан тушаалын албан үүргийг түр  
орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Цахим хаяг: [enhtsoodolj@audit.gov.mn](mailto:enhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: А.Сувдаа

Утас: 70342495

Цахим хаяг: [suvdaaa@audit.gov.mn](mailto:suvdaaa@audit.gov.mn)



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.24 № 200  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БУЛГАН СУМЫН ТОХИЖИЛТ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЙН ДАРГА  
Ц.ДАВААДОРЖ АНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Тохижилт үйлчилгээний ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хөрөнгийг орлого авч тайлан бүртгэлд тусгаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, бүрдэл дутуу зарцуулалт хийсэн, албан хаагчдад цалин илүү олгосон зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг

632502327

шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсны дагуу олгосон байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос өссөн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудал**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН  
АЛБАН ҮҮРГТИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ

## Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөг/

Үзүүлэлт	2023.12.31	2023.12.31.
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	30,688.0	87,713.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	9,965,517.8	11,918,520.1
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>9,996,205.8</b>	<b>12,006,233.3</b>
Нийт өр төлбөрийн дүн	1,340.5	2,469.5
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,994,865.3	12,003,763.8
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>9,996,205.8</b>	<b>12,006,233.3</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>		
Үйл ажиллагааны орлогын дүн	4,399,202.5	5,310,494.5
Үйл ажиллагааны зардлын дүн	1,730,554.8	3,279,778.8
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>2,668,647.7</b>	<b>2,030,715.8</b>
Үйл ажиллагааны бус үр дүн	-	(21,817.3)
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>2,668,647.7</b>	<b>2,008,898.5</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,326,217.6	9,996,164.3
Тайлант оны үр дүн	2,668,647.7	2,008,898.5
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>9,994,865.3</b>	<b>12,005,062.8</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,059,868.5	2,032,579.1
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,059,868.5	2,032,579.1
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	-	-
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	-	-
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	-	-
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>		
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	-	1,964,816.6
Урсгал зардал	-	1,964,816.6
Хөрөнгийн зардал	-	-
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	-	1,964,816.6
Улсын төсвөөс санхүүжих	-	-
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

### Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тайлант онд тус байгууллага “Төрийн байгууллагын туслах үйл ажиллагааг ханган, иргэдийн аюулгүй байдал, тав тухтай орчин бүрдүүлэх” зорилгын хүрээнд ажилласан байна.

### Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 178,020.4 мянган төгрөгийн 18 удаагийн зарлагын гүйлгээг бүрэн мэдээлээгүй нь нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын

дүн”, 6.4.8-д “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтын 3.2.10-т “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар тус тус тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэн, зөв мэдээлж хэвших, албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

### **Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Батлагдсан орон тоо, бүтцийн гүйцэтгэл, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын 2019 оны 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журам, аймгийн ИТХ-ын 2024 оны 25/08 дугаар тогтоолыг хэрэгжилтийг хянах үзэх.

### **Зургаа. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 1,664,997.7 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Гэрээний дагуу худалдан авалтад ногдох урамшууллын 1,450.0 мянган төгрөгийн шатахууныг тайлан бүртгэлд дутуу тусгасан УСНББОУС-1, 12, тохиолдсон байх,
- Аймаг, сумын ОНХС, БХС, ОНХО-аас санхүүжиж хийгдсэн 1,662,112.7 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн тусгаж бүртгээгүй нь УСНББОУС-17, иж бүрэн байх батламж мэдэгдэл,
- Тайланд онд 1,435.0 мянган төгрөгийн өглөг дутуу бүртгэж тайлагнасан УСНББОУС-1, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Аудитаар нийт 49,027.4 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 7,027.4 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт, 42,000.0 мянган төгрөгт 5 албан шаардлага өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 49,027.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 23,069.1 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

#### **6.1 Төлбөрийн акт**

1. Гэрээний дагуу шатахууны урамшуулалд олгосон талоноос анхан шатны баримтгүй нийт 5,270.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7, 20.1.4, 20.2.4 дэх заалтыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг улсын орлого болгох.

2. Төрийн албаны тухай хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулсан Тохижилт үйлчилгээний ангийн даргад улирлын үр дүнгийн урамшуулал 686.0 мянган төгрөг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123.8, Төсвийн тухай хуулийн 16.5.3, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг улсын орлого болгох.

3. Ажилчдад илүү цагаар ажилласан нэмэгдэл хөлсийг олгохдоо 774.4 мянган төгрөгийг илүү тооцоолж олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.2, 20.2, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 3.3, Төсвийн тухай хуулийн 16.5.1-т тус тус заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг улсын орлого болгох.

4. Байгууллагын дотоод журамд заасны дагуу нэг удаагийн тэтгэмж урамшуулал олгохдоо 300.0 мянган төгрөгийг давхардуулж олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7 дахь заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг улсын орлого болгох.

## **6.2 Албан шаардлага**

1. Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 64 нэр төрлийн 266 тооны үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаа нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах шилжүүлэх журам", аймгийн ИТХ-ын 2024 оны 25/06 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлэх, данс бүртгэлээс хас ажлыг зохион байгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлэх.

2. Тайлант онд хогийн цэгт шинээр нийт 19,900.0 мянгна төгрөгөөр хог түрэх машины гарж шинээр барьсан боловч санхүүгийн тайлан орлого авч бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1, 14.4.2, 20.2.6-д заасныг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийг зөрчсөн зөрчлийг арилгаж хөрөнгийг орлогод авч бүртгэлд тусгах

3. Тайлант онд өөрийн үйл ажиллагааны орлогоор нийт 15,600.0 мянган төгрөгийн орлогын анхан шатны баримт байхгүй баримт дутуу нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5-д , 20.1.4, 20.2.4, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалыг тус тус бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль, тогтоомжийг зөрчсөн зөрчлийг таслан зогсоож, бэлэн мөнгөний тайланг гарган хэвшиж

4. Гэрэл засварын ажлыг "Энх алтун" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн ч 6,500.0 мянган төгрөгийн холбогдох анхан шатны баримтын бүрдэл дутуу нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6-д заасныг зөрчсөн, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрдлийг санхүүгийн баримтад бүрэн тусгах,

5. Санхүүгийн тайлангийн иж бүрдэл дутуу, санхүүгийн тайланг бэлтгэхдээ эрх үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй, шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчлийг давтан гаргасан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтын 3.2.10, 3.2.11 дэх зөрчлийг давтан гаргасан, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодогчид хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах

### 6.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй болно.

### Долоо. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган.төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТҮА	3	1,664,997.7	3	1,664,997.7	0	-	3	1,664,997.7	0	0	0	0
Дүн	3	1,664,997.7	3	1,664,997.7	0	-	3	1,664,997.7	0	0	0	0

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТҮА	9	48,341.4	4	7027.4	4	42,000.0	0	-	1	1	0	0
Дүн	9	48,341.4	4	7027.4	4	42,000.0	0	-	1	1	0	0

#### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТҮА	1	178,080.4	0	-	1	178,080.4	0	-
Дүн	1	178,080.4	0	0	1	178,080.4	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	1	178,080.4	0	0	1	178,080.4	0	0

### Найм. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудит ад хамраг	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлал ттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагалаасан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		

-oOo-